



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/196

Мандалговь

Хүүхдийн элч сонгон шалгаруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.4.1, 20 дугаар зүйлийн 20.6, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 2.1.6 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хамтран зохион байгуулах, хяналт тавих зорилгоор “Хүүхдийн элч” нарыг сонгон ажиллуулах журмын дагуу шалгаруулсугай.

2. Хүүхдийн элч нарыг Андгай өргүүлэн Гэрээг гардуулж эрхийг баталгаажуулсугай.


3. Хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол улсын үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, эдгээр журам болон бусад холбогдох хууль, эрхийн актыг дагаж мөрдөж ажиллахыг хүүхдийн элч нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг нийгмийн бодлогын мэргэжилтэн (О.Уранзаяа)-д үүрэг болгосугай.

5. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 40,000 (дөчин мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), ня-бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ



Сайнцагаан сумын Засаг даргын
2021 оны 11 сарын 18 ны өдрийн
А/196 дугаар захирамжийн хавсралт

№	Нэр төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	ГЭРЭГЭ	5	8000	40000